



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/53

Ханх сум

**Малын Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.12, Захиргааны ерөнхий хуулийн 40.1, 40.2, 40.3, 40.4, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, аймгийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 31-ний өдрийн А/395 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Малын Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээнд бүх эм тугал, хурга, ишгийг хамруулан 2024 оны 08-р сарын 12-ны өдрөөс 09-р сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлыг дээрх хугацаанд технологийн дагуу хийж гүйцэтгэхийг "Мундрага" Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эзэн /Б.Баясгалан/-д, дархлаажуулалтын товыг малчдад зарлан мэдээлэх, шаардлагатай хүн хүн хүчээр хангаж ажиллахыг Тураг 1-р багийн Засаг дарга Ш.Отгонжаргал, Хороо 2-р багийн Засаг дарга Б.Анхбаяр, Турт 3-р багийн Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Мөнхжаргал, Баясгалант 4-р багийн Засаг дарга Б.Бямбабаяр нарт, дархлаажуулалт хийх үед товлосон хугацаанд малаа бэлэн байлгаж, бүрэн хамруулах, малаа барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж, малын эмчийн аюулгүй байдлыг хангаж хамтран ажиллахыг малчид /мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

3. Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулж, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр ханган захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч /Э.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л. ДАВААБАЯР

